2021 оны 05 сарын 27-ны өдөр Дугаар А/393 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 ”в”, 29.2, 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 146 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсэгт шаардлагатай мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, бусад баримт бичгийг тухай бүр шуурхай гаргаж, дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч, Төслүүдийн удирдагч нар болон Нийслэлийн харьяа нутгийн захиргааны байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай ажлын байр, компьютер техник хэрэгсэл, автомашин бусад нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Т.Оюунчимэг)-т зөвшөөрсүгэй.

4.Дээрх цогц арга хэмжээний төлөвлөгөө, явц, биелэлтийг сар бүрийн хоёр дахь долоо хоногт Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд, сар бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Ч.Батзориг)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 27-ны өдрийн
А/393 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Төсөл, хөтөлбөр хариуцсан зөвлөх Ч.Батзориг
Гишүүд:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого,төлөвлөлтийн хэлтсийн дарга А.Мөнхболд
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Аясгалан
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Н.Наранбаатар
	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга Ж.Гал
	Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга Г.Баярсайхан
	Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газрын дарга С.Энхтөр
	Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дарга О.Чинзориг
	Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын орлогч дарга Х.Булгаа
	Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын дарга Л.Тулгабаатар
	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер Т.Оргил-Эрдэнэ

Хот төлөвлөлт, судалгааны институтийн ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер Ж.Баясгалан

Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техникийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Аззаяа

Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Ш.Мөнхжаргал

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Тэмүүжин

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ийн гүйцэтгэх захирал Н.Баярчимэг

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Гэрээ, санхүү, эдийн засгийн салбарын эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Солонго

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Замын хөдөлгөөн, нийтийн тээврийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Ж.Оюунжаргал

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтсийн Төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Б.Бүжинлхам

Хот байгуулалт, хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяа

Нарийн бичгийн дарга:

Хот байгуулалт, хөгжлийн газрын Ерөнхий архитекторын ажлын албаны Ахлах мэргэжилтэн Г.Дарханчулуун

Нийслэлийн Автозамын хөгжлийн газрын Бодлого хэрэгжилтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 27-ны өдрийн
А/393 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

Ажлын хэсгийн ажиллах удирдамж

Нэг. Үндэслэл

1.1.“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын цогц арга хэмжээний төлөвлөгөө” (цаашид “цогц хөтөлбөр” гэх)-г боловсруулахдаа дараах үндэслэлийг харгалзана.

1.1.1.Улаанбаатар хотын иргэд, оршин суугчдын ажиллаж амьдрах таатай, эрүүл, аюулгүй орчин болон нийгэм, эдийн засгийн нөхцөл хангалтгүй;

1.1.2.Нийслэлийг зорьсон шилжилт хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэж Улаанбаатар хотын хот төлөвлөлт, авто замын түгжрэл, агаарын бохирдолд их хэмжээгээр нөлөө үзүүлж байгаа тул зарим томоохон албан байгууллага, зах, олон нийтийг хамарсан худалдааны төвийг нүүлгэх төлөвлөлтийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, хэт төвлөрлийг бууруулахад гудамж зам талбайд олон тоогоор барьсан хайс, хашаа, хаалт, граш зэрэг газар ашиглалтыг сайжруулан хотын эдийн засгийг дэмжих төлөвлөлт хийх шаардлагатай;

1.1.3.Нийслэлийн хот төлөвлөлтийн бодлого сүүлийн 30 гаруй жил алдагдсанаас хотын дэд бүтэц, авто замын сүлжээ ачааллаа дийлэхээ больж, авто машины түгжрэл, агаарын бохирдол ихээр нэмэгдэж байгаа нь нийгэм, эдийн засгийн амьдралд сөрөг нөлөө үзүүлж байгаа зэрэг болно.

1.2.Цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинэчлэл хийх байгууламж, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалт болон нөхцөл байдлын талаарх танилцуулга, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, 2021 оны 06 сарын 15-ны дотор Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулна.

Хоёр. Зорилго

2.1.Ажлын хэсгийн зорилго нь дээр дурдсан цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах хүрээнд Нийслэлийн зарим гол, туслах замыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр барих, автомашины урсгалыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалт хийх, нэвтрэх чадварыг сайжруулан зорилгоор шинээр нүхэн гарц, уулзвар, гүүрэн байгууламж барих, нийслэл хотын байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан түр байгууламжуудыг буулгах, томоохон хөдөлгөөний нягтшилтай газруудыг нүүлгэх, дэд бүтэц, авто замын оновчтой сүлжээг бий болгох, Туул гол дагуу болон их тойруу хурдны шинэ зам барих, гэр хорооллын дэд бүтцийн хөгжлийг дэмжиж нийтийн тээврийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, нийтийн тээврийн парк шинэчлэл хийх замаар хот төлөвлөлтийн шинэ шийдлүүдийг хэрэгжүүлэх, тэдгээрийн цогц төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх суурь судалгааг хийх, санхүүжилтийн эх үүсвэрийн суурь схемийг тооцоолж гаргахад оршино.

2.2 Төсөл, арга хэмжээний эдийн болон нийгмийн үр өгөөжийг урьдчилсан байдлаар тооцох, төсөл дуусаны дараа ашиглалтын зардлын урьдчилсан тооцоолол гаргах;

2.3 Нэгдсэн цогц хөтөлбөрт хамрагдах төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь нэн яаралтай болон яаралтай, дунд хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ гэж эрэмбэлэх;

1. Нэн яаралтай буюу энэ онд багтаан багтаамж ихтэй нийтийн тээврийн шинэ төрөл болох LRT-г барьж байгуулах ажил, нийтийн тээврийн парк шинэчлэлт, авто замын сүлжээг өргөтгөх, авто зогсоолыг нэмэгдүүлэх, барилга угсралтын ажлын зураг төсөл боловсруулж, батлуулах талаар судалгаа, тооцоо хийх.
2. Яаралтай буюу ирэх жилд явган болон дугуйн зам, авто замын өргөтгөл шинэчлэл, уулзвар, нүхэн гарц, гүүрэн байгууламж барих ажлыг эхлүүлэх болон буруу жолооны хүрдтэй болон 10 жилээс дээш насжилттай тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах, хотод оношилгоонд ороогүй буюу тэнцээгүй, торгууль төлөөгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд оролцохыг хориглох зэрэг зайлшгүй авч хэрэгжүүлэх ажлын талаар тооцоолол, судалгаа хийх.
3. Дунд хугацаанд буюу 2022-2024 онд хотын төвийг задлах эдийн засаг, зохицуулалтын арга хэмжээ болох томоохон зах худалдааны төвийг нүүлгэх, автомашины даатгал, хураамжийг бүсчлэн нэмэх, Ачааны терминал, логистикийн төвийг байгуулах талаар тооцоо судалгаа хийх.

Гурав. Ажлын хэсгийн хамрах цар хүрээ

3.1.Цогц хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах дараах үндсэн үзэл баримтлал (концепц)-ыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ менежментийн арга хэмжээ;
2. Дэд бүтэц, авто замын сүлжээг өргөтгөн шинэчлэх арга хэмжээ;
3. Хот төлөвлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээ;
4. Бодлого төлөвлөлт, эрх зүйн зохицуулалтын арга хэмжээ;

3.2.Зураг төсөл зохиох, боловсруулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниудын нэгдсэн жагсаалтыг гаргаж, чадамжийг үнэлэх, үйл ажиллагаатай нь газар дээр нь танилцах;

3.3.Сангийн яамны харьяа “Хөгжлийн хөтөч” төслийн хэрэгжүүлж байгаа боловч олон жил хугацаа алдсан Нийслэл хотод гүйцэтгэх БНХАУ-ын ЭКСИМ банкны зээлийн санхүүжилттэй “Туул, Сэлбэ гол орчмыг сайжруулах төсөл” болон “Нүхэн гарц төсөл”-ийг энэхүү цогц хөтөлбөрт хамруулахын тул Нийслэлд буцааж шилжүүлэх ажлыг зохион байгуулах.

Дөрөв. Ажлын хэсгийн зорилт, хэрэгжүүлэх ажил

4.1.Ажлын хэсгийн зорилтын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1.Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ менежментийг нэвтрүүлэх чиглэлээр;

1. Нийт шаардлагатай нийтийн тээврийн тоо, одоо байгаа автобусны насжилт, шинээр авах автобусны үнэ өртгийн урьдчилсан тооцооллын судалгаа, нийлүүлэх хугацааны төлөвлөгөө гаргах;
2. Такси үйлчилгээний нийт хэрэгцээ шаардлага, тавигдах стандарт, иргэдийн хүсэлт, сонирхлын талаар судалгаа гаргах.

4.1.2 Дэд бүтэц, авто замын сүлжээг өргөтгөн шинэчлэх чиглэлээр;

1. Ухаалаг удирдлагын системд нэвтрүүлэх буюу тээврийн хэрэгсэл зорчих уулзвар гудамжийг камержуулах, гэрэлтүүлгийг хосолсон буюу hybrid хамгаалалтын системд шилжүүлэх ажлыг авто замын өргөтгөл шинэчлэлийн ажилд уялдуулж тусгуулах;
2. Инженерийн шугам сүлжээ (цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, харилцаа холбоо)-ний одоогийн түвшин дэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх;
3. Хотын ерөнхий удирдлага зохицуулалтад хамгийн их түгжрэлтэй гол замын ачаалалтай байршил, туслах чанарын хороолол доторх зам болон хурдны их тойруу авто замын сүлжээ байгуулах, өргөтгөх замын чиглэлийн байршлыг тогтоох;
4. Явган хүний зам болон дугуйн замын чиглэл байршлыг тогтоож, хэмжээг урьдчилсан байдлаар тооцоолох;
5. Бусад авто замын талаар авах шаардлагатай судалгаа, тооцоо хийх.

4.1.3.Хот төлөвлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн чиглэлээр;

1. Нүүлгэн шилжүүлэлт, газар чөлөөлөлтөд өртөж болох газруудын байршил тогтоох;
2. Хотын түгжрэлийн цэгээс нэн даруй нүүлгэх боломжтой томоохон байгууллага, объектуудын жагсаалтыг гаргах;
3. Түр байгууламжаар газар эзэмшиж байгаа, зөвшөөрөлгүй нийтийн эзэмшлийн зам талбайд хашаа, хаалт, граш болон байгууламж барьсан газрын байршилд авто зам өргөтгөх, шинэчлэх боломжтой байршлуудыг тогтоох.

4.1.4.Бодлого төлөвлөлт, эрх зүйн зохицуулалтын чиглэлээр;

1. Шинээр батлагдсан гарах хуулийн үзэл санаа, бодлогод нийцүүлж нийслэлийн тусгай чиг үүрэгт нийцсэн журам гаргах замаар Автомашины урсгалыг бууруулах бололцоо нөхцөлийг судалж тогтоох;
2. Хотын гудамж талбайг зэрэглэл тогтоож, төлбөртэй болгох ингэснээр төлбөргүй түгжрэлгүй гол замыг ашиглахгүй тойрог зам сонгох зохицуулалт хийх боломжийг судлах;
3. Тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөний тоог бууруулах чиглэлээр судалгаа хийх;
4. Шинээр хийгдэх зогсоолын байршил тэдгээрийн бүртгэлийн ухаалаг системийн талаар судалгаа хийх;
5. Авто зам, уулзвар, ногоон байгууламжийг жишиг болгон барьж байгуулах боломжийг судлах;
6. Зарим төслийг татан буулгаж, нэгтгэж нийлүүлэх замаар төсөв хөрөнгө хэмнэх, ажлын давхардал гаргахгүй байх, мэдээллийн нэг цонхны нэгдсэн төлөвлөлт бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтын санал боловсруулах;
7. Батлагдсан нарийвчилсан иж бүрэн ажлын зураг төсөлтэй нүхэн гарц барих зэрэг зарим төсөл, арга хэмжээний барилгын ажлыг эхлүүлэх талаар судлах.

4.1.5.Нийт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт гаргах үүнээс нэн тэргүүн 2022 онд эхлэх ажлын жагсаалтыг гаргах. Гаргасан жагсаалтын дагуу ажил тус бүр дээр зургийн даалгавар боловсруулах, инженер геодези, байр зүйн дэвсгэр зургийн суурь судалгаа хийх, зураг төсөл боловсруулах, батлуулах зэрэг нийт хугацааг тооцоолж, зураг төсөл зохиох гүйцэтгэгч нарыг багцлах, ажлын тоо хэмжээ болон хийж дуусах хугацааг тодорхойлох;

4.1.6.Нийт төсөл, арга хэмжээг он дараалаар нь үндсэн хоёр үед хуваах, ач холбогдол, төвөгшил, санхүүжилтийн эх үүсвэрээр нь эрэмбэлэх;

4.1.7.Ажлын зураг төслийг 2 үе шаттайгаар боловсруулан, урьдчилсан эхний зургаар магадлал хийж батлуулах боломжийг судалж, хугацаа хэмнэх боломж нөхцөлийг эрэлхийлэх;

4.1.8.Зураг төсөл боловсруулахтай холбоотой, зургийг чанартай, ажлын тоо хэмжээ орхигдуулах, урьдчилсан суурь судалгааг буруу хийх зэрэг гарч болох эрсдэлийг бууруулах чиглэлээр мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоотой хамтарч ажиллах үндсэн үзэл санааг томьёолох, барилгын ажилд хяналт тавих үндсэн төрлийн зарчмын санал боловсруулж, цаг хэмнэх, ажлыг чанартай гүйцэтгүүлэх, төслийн үр өгөөжийг бүгдэд тэгш хүртээх боломж арга замыг эрэлхийлэх.

Тав. Ажлын хэсгийн санхүүжилт

5.1.Ажлын хэсэгт ороогүй боловч татан оролцуулах шаардлагатай гэж үзвэл нийслэлийн хэрэгжүүлэгч агентлаг, бусад байгууллага, төсөл хэрэгжүүлэх нэгж, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллийг ажиллуулж, цалин хөлс, нэмэгдлийг нийслэлийн Засаг даргын Тамгын газраас санхүүжүүлнэ.

5.2.Ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг холбогдох Нийслэлийн санхүүжилтийн сангаас санхүүжүүлнэ.

Зургаа. Ажлын хэсгээс гарах үр дүн ба дуусгавар болох

6.1.Цогц хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний үндсэн үзэл баримтлал (концепц) нь нийслэл хотын иргэд, оршин суугчдын ажиллаж амьдрах таатай орчин болох түгжрэлийг бууруулах бодит байдалд нийцэхүйц төлөвлөлттэй болно.

6.2.Үндсэн үзэл баримтлалаас уялдаж хэрэгжүүлэх ажлын цар хүрээ тодорхой болж, тэдгээрийн санхүүжилтийн схем, эх үүсвэрүүдийг тодорхойлох, төсөл, арга хэмжээ хэрэгжих хугацаа, дараалал, ач холбогдлыг эрэмбэлнэ.

6.3.Цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргачлалыг тодорхойлж, хэрэгжих хугацааны нэгдсэн товьёгтой болно.

6.4.Дараах нөхцөлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд төслийг дуусгавар болсонд тооцно:

6.4.1.Төслийг хэрэгжүүлэх хүрээнд бүх төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалт гарч, тэдгээрийг хийх хугацааны товьёг батлуулж, санхүүжүүлэх эх үүсвэрийн нэгдсэн схем батлагдах зэрэг ажлууд бүрэн хэрэгжсэн;

6.4.2.Ажлын хэсгээс цогц хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажлыг гардан гүйцэтгэх субъект байгуулагдсан;

6.5.Ажлын хэсэг нь цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн концепц түүнтэй холбоотой баримт бичиг, материалыг төсөл хэрэгжүүлэх байгууллагад хүлээлгэн өгнө.

- o0o -